



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 07

Баянбулаг

Хоршоог хөгжүүлэх сангаас олгох  
зээлийн тэргүүлэх чиглэл, дээд  
хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.3.4, Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/124 тоот захирамжийг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын IX Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн түүхий эд, нөөц боломж, давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлж орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг оновчтой зохион байгуулж хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор сумын “Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо (Загвар хоршоо)” “Газар тариалан”, “Мал, амьтны тэжээл, тариалалт, үйлдвэрлэл”, “Арьс шир боловсруулах”, “Мах махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах”, “Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, “Эрчимжсэн мал аж ахуй”, “Бэлчээрийн мал аж ахуй”, “Аялал жуулчлал”, “Орон нутгийн онцлогт брэнд бүтээгдэхүүн” үйлдвэрлэлийг тэргүүлэх чиглэл гэж үзсүгэй.

2.Төсөлд олгох зээлийн дээд хэмжээг 100 000 000 (Нэг зуун сая) хүртэлх төгрөг байхаар тогтоосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ны 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.НАМГАРРЕНЧИН



648803018



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 04

Баянбулаг

**Санг өөрчлөн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 1.1дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 81 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Суманд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор сум хөгжүүлэх санд төвлөрсөн хөрөнгийг зарцуулах сум хөгжүүлэх санг, хоршоо хөгжүүлэх сан болгон өөрчилсүгэй.

2.Холбогдох хууль тогтоомж журмын хүрээнд өөрчлөн шинэчлэгдсэн хоршоо хөгжүүлэх санг удирдлага зохион байгуулалтаар ханган үр дүнд хүргэж ажиллахыг сумын Засаг дарга (Н.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА  Б.НАМГАРРЕНЧИН



648803012